



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

“Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн орон нутагт хамааралтай заалтын хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайлан /ДУА-2018-03-НА/



Архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоходоо 13.7 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийг дутуу төвлөрүүлсэн байна.



Тусгай зөвшөөрөлгүй 8 цэг тамхи худалдаалсан байна.



ЭМЧМҮАЭ зөвшөөрөл олгох комисс хяналт хийгээгүй байна.



Тусгай зөвшөөрөлтэй төсвийн 40 сургууль, цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байна.



Агаарт бохирдуулах бодис гаргадаг физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг үйлдвэрлэл эрхлэх, суурин эх үүсвэр ашиглах тусгай зөвшөөрөл олгоогүй байна.



Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль орон нутагт хэрэгжихэд хүндрэлтэй байна.

Аймгийн хэмжээнд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

2018 он

АГУУЛГА

| | | |
|--|--|--|
| | Товчилсон үгс | 3 |
| <u>Тайланг бэлтгэсэн:</u> Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар Дарга, тэргүүлэх аудитор П.Төвсанаа Аудитын менежер Х.Наранцацral Ахлах аудитор Д.Ихбаяр Аудитор Д.Должинсүрэн | Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, үндсэн мэдээлэл Бүлэг 1. Тусгай зөвшөөрлийг хууль, журмын дагуу олгоогүйгээс орон нутгийн орлогод 15.5 сая төгрөгийн орлого дутуу төвлөрсөн байна. 1.1 Тусгай зөвшөөрөл олгоход баримтлах нормативыг тогтоосон хууль эрх зүйн орчин хангалтгүй байна. 1.2 Тэмдэгтийн хураамж төлөөгүй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд тусгай зөвшөөрлийг олгосон байна. Бүлэг 2. Орон нутгаас олгогдсон тусгай зөвшөөрөлд тавих хяналт хангалтгүй байна. 2.1. Архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагууд гаалийн шинжилгээний бичиггүй импортын архи худалдаалж байна. 2.2. Тусгай зөвшөөрлийн хэрэгжилтэнд хяналт тавих эрх бүхий байгууллагуудын хяналт хангалтгүй байна. 2.3. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг бүртгэж, шийдвэрлээгүй байна. | 4-8 9-13 14-17 17-20 21-22 22-23 23-24 24-27 27 28-32 33 34-46 47-54 |
| Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70592225 дугаарын утсаар харилцана уу. Уг тайланг ҮАГ-ын вэб сайтаас үзнэ үү. www.audit.mn | Дүгнэлт Зөвлөмж Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал Шалгагдагч байгууллагаас ирсэн санал, тайлбар Төрийн аудитын газрын тайлбар Тайлан баталгаажуулах тушаал Тайлангийн хавсралтууд | |
| Хаяг: Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 2 давхар | | |
| 2018 оны 5 дугаар сар | | |

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|-----------------|---|
| УИХ | Улсын Их Хурал |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| АДБОУС | Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт |
| ҮАГ | Үндэсний аудитын газар |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ЭМЧМУАЭ | Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх |
| ХОХБТ | Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлт |
| ЭМСС | Эрүүл мэнд, спортын сайд |
| ҮХ | Үйлдвэр худалдаа |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ИТХТ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчit аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| МХГ | Мэргэжлийн хяналтын газар |
| ТЗ | Тусгай зөвшөөрөл |
| ТТАМ | Түгээмэл тархацтай ашигт малтмал |
| ГЗБЕТ | Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө |

ГРАФИК БОЛОН ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

| | |
|------------------|--|
| Хүснэгт 1 | Тусгай зөвшөөрөл олгоходо баримталж байгаа чиглэл, норм, норматив, байршлын танилцуулга |
| Хүснэгт 2 | Эрүүл мэндийн чиглэлээр олгосон тусгай зөвшөөрлийг салбарын тэргүүлэх чиглэл болон орон нутгийн хэрэгцээ шаардлагатай харьцуулсан судалгаа |
| Хүснэгт 3 | Тусгай зөвшөөрөл шинээр олгосон, сунгалт хийсэн байгууллагын too |
| Схем 1 | Архи, согтууруулах ундаа түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн норматив хэмжээг тогтоосон эрх зүйн зөрчилтэй актууд |
| Схем 2 | Тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжтай холбоотой эрх зүйн актууд |
| График 1 | ЭМЧМУАЭ тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгуулла |
| График 2 | Согтууруулах ундаа худалдаа, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олголт, нормативын харьцуулалт /сумдаар/ |
| График 3 | Тусгай зөвшөөрөл шинээр олгосон, сунгалт хийсэн байгууллагын too |

АУДИТЫН НЭР: “АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН

ТУХАЙ ХУУЛИЙН ОРОН НУТАГТ ХАМААРАЛТАЙ ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТ”

АУДИТЫН КОД: ДУАГ/2018/НА-03

АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ:

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2018 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2018 онд хийх аудитын төлөвлөгөө”, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу аймгийн ИТХ-ын захиалгаар Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийллээ.

НИЙЦЛИЙН АУДИТЫН ЗОРИЛТ

Орон нутгаас олгож буй тусгай зөвшөөрөл олголт болон түүнд тавих хяналт хууль журмын дагуу хийгдэж байгаа эсэхэд аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдлээ.

ДЭД ЗОРИЛТ

- Орон нутгаас олгож байгаа тусгай зөвшөөрөл олголт хууль журмын дагуу явагдаж байгаа эсэх;
- Тусгай зөвшөөрлийн хяналт, үр дүнтэй байгаа эсэх.

АУДИТЫН ХАМАРСАН ХҮРЭЭ

Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтнүүд, ЭМЧМЧУАЭ тусгай зөвшөөрөл олгох комисс, аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын баримт материал, аймаг, сумдын эрх бүхий ажилтнуудын гаргасан тушаал, шийдвэрүүд, тусгай зөвшөөрөл олгох комиссын хурлын тэмдэглэл, холбогдох бусад эрх зүйн актуудад тулгуурлан 2015-2017 оныг хамруулан аудитыг гүйцэтгэлээ.

АУДИТЫН АРГА ЗҮЙ

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 400, 4100 дугаар стандартууд, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлав.

Аудитын хөтөлбөр, горим, арга зүйн дагуу цуглувансан нотлох зүйл, баримт материалд дүн шинжилгээ хийх, зорилт арга хэмжээний хэрэгжилтийг түүвэрлэн шалгах, судалгаа авах, мэдээллийн эх үүсвэртэй тулган шалгах арга зүйг ашиглалаа.

АДБОУС, Төрийн хяналт шалгалтын стандартад заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт

материалд хавсаргав.

АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

- Аудитын Олон Улсын стандарт;
- Төрийн аудитын тухай хууль;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль;
- Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль;
- Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Боловсролын тухай хууль;
- Эрүүл мэндийн тухай хууль;
- Тамхины хяналтын тухай хууль;
- Эрчим хүчний тухай хууль;
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль;
- Засгийн газрын 2011 оны 199 тогтоол /Улсын тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээг тогтоох тухай/;
- Засгийн газрын 2013 оны 191 тогтоол /“Тамхины үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих журам”/;
- Үйлдвэр худалдааны сайдын 2005 оны 110 тоот тушаал /Норматив тогтоох тухай/;
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2011 оны 142 дугаар тогтоол /Улсын тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээг тогтоох тухай/;
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 43 дугаар тогтоол /Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам/;
- Аймаг, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол, шийдвэр, журмууд, аймгийн Засаг даргын шийдвэрүүдийг шалгуур болгон ашиглав.

АУДИТЫН ХУГАЦАА, БАГИЙН БҮРЭЛДХҮҮН

Аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг 2018 оны 02 дугаар сарын 19 –ны өдрөөс эхлэн 05 дугаар сарын 14-ний өдрийг хүртэл хугацаанд тэргүүлэх аудитор П.Төвсанаа хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацral үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Ихбаяр, аудитор Д.Должинсүрэн нар хийж гүйцэтгэлээ.

АУДИТЫН ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ, ТҮҮНД ТУСГАГДСАН МЭДЭЭЛЭЛ

Аудитын тайлангийн нэгдүгээр бүлэгт орон нутгаас олгож байгаа тусгай зөвшөөрлийг хууль, журмын дагуу олгож байгаа эсэх, хоёрдугаар бүлэгт орон нутгаас олгогдсон тусгай зөвшөөрөлд тавих хяналт хууль, журмын дагуу хийгдэж байгаа эсэх талаар тусгаж, аудитын дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

АУДИТЫН ЯВЦАД ТУЛГАРСАН ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ

Аудитын явцад аймгийн ЗДТГ-ын ХОХБТ-ийн хэлтсийн холбогдох мэргэжилтнүүд мэдээ, судалгаа, баримт материалыг шаардсан хугацаанд ирүүлээгүй, ирүүлсэн зарим мэдээлэл нь шаардлага хангахгүй байсан зэргээс аудитын хөтөлбөрийн хугацаа алдагдахад хүрсэн.

Аудитын явцад шаардлагатай баримт материал, судалгааг цаг хугацаанд бүрэн гаргаж өгөлгүй төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд саад учруулсан, аудит хийх нөхцөл боломжоор хангаагүй Цагаандэлгэр сумын мал эмнэлэг, үржлийн тасгийн дарга Т.Өлзийбат, аймгийн ЗДТГ-ын ХОХБТ-ийн хэлтсийн худалдаа үйлдвэрлэл үйлчилгээ, хоршооны бодлого хариуцсан мэргэжилтэн Д.Энхтуяа, байгаль орчин аялал жуулчлал, ашигт малтмал, уул уурхайн бодлого хариуцсан мэргэжилтэн П.Очирбат нарт хариуцлага тооцуулах албан шаардлагыг харьяа байгууллагын удирдлагад нь хүргүүлж, сахилгын шийтгэл ногдууллаа.

АУДИТЫН ДҮН

Аудитаар нийт 15,550.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, аудитын явцад 1,050.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулж, 14,500.0 мянган төгрөгийн хохирлыг барагдуулахаар хугацаатай төлбөрийн акт тогтоож, 3 албан тушаалтанд зөрчлийг арилгуулах, 3 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах хугацаатай албан шаардлага хүргүүллээ.

Аудитаар илэрсэн зөрчлийг агуулгаар нь авч үзвэл дараах зөрчлүүд илэрсэн байна.
Үүнд:

- Тэмдэгтийн хураамж төлөөгүй байгууллагад тусгай зөвшөөрөл олгосон;
- Норматив мөрдэж ажиллаагүй;
- Тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгалт хийхдээ сонгон шалгаруулалт хийлгүй хяналтгүй олгосон;
- Согтууруулах ундаа, тамхи худалдах тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг харилцан адилгүй ногдуулан хураасан;
- Эрүүл мэндийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг улсын төсөвт төвлөрүүлсэн;
- Тэмдэгтийн хураамжийн тайланг гарган, Татварын хэлтэст хүргүүлж, тооцоо нийлээгүй;
- Импортын архийг гаалийн шинжилгээний бичиггүй худалдаалсан;
- Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид согтууруулах ундаагаар үйлчлэх зөвшөөрлийг хууль зөрчиж олгосон;
- Тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааг зөвшөөрөлгүй эрхэлсэн;
- Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангаж ажиллаагүй аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох талаар арга хэмжээ аваагүй;
- Тусгай зөвшөөрлийн олголт, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжид хяналт хангалтгүй тавьсан;
- Тусгай зөвшөөрөлтэй холбоотой иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг бүртгэж, шийдвэрлээгүй;

- Архи согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийн сунгалтыг хуулийн хугацаанд шийдвэрлээгүй;
- Мэдээ, судалгаа, баримт материалыг шаардсан хугацаанд ирүүлээгүй;
- Ирүүлсэн зарим мэдээлэл нь шаардлага хангагүй.

Зөрчлийн агуулгаас харахад тусгай зөвшөөрлөөр үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн төрөл бүр дээр дутагдал гарсан боловч ихэвчлэн согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн олголттой холбоотой зөрчил дутагдал дийлэнх хувийг эзэлж байгаад дүгнэлт хийж, уг асуудлаар хэлтсийн дарга болон ажил хариуцсан мэргэжилтэнд ажлын хариуцлага, ёс зүйг сайжруулах үүрэг даалгавар өгч, зөрчил дутагдлыг бүрэн арилгуулж, шаардлагатай гэж үзвэл эрх хэмжээнийхээ хүрээнд дахин арга хэмжээ тооцож ажиллах шаардлагатай болсон байна.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар аймгийн Засаг дараах аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгодог. Үүнд:

- Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх;
- Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах;
- Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх;
- Эмчилгээний гоо заслын үйлчилгээ;
- Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах.

Харин сумын Засаг дарга нь дараах аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгож байна. Үүнд:

- Агаарт бохирдуулах бодис гаргадаг физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг үйлдвэрлэл эрхлэх, суурин эх үүсвэр ашиглах;
- Тамхи худалдах.

Аймгийн хэмжээнд тусгай зөвшөөрөлтэй нийт 40 сургууль, цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд бүгд орон нутгийн төсвийн байгууллага байна.



График 1Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 71 байгууллага байгаа бөгөөд үүнээс анхан шатлалын эмнэлэг 17, 2 дахь шатлалын эмнэлэг 2, эмэгтэйтэйн сан 15, эм ханганд нийлүүлэх төв 3, хувийн эмийн сан 9 ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр 3-н суманд 3 сувилал ажиллаж, хувийн эмнэлгийн үйл ажиллагаа эрхэлдэг 22 байгууллага байгаас 7 буюу 31.8 хувийг нүүр амны өвчний оношилгоо, эмчилгээ, хиймэл шүдний эмнэлгүүд эзэлж, 3 буюу 13.6 хувийг ахуйн хортон шавьж, мэрэгч хорхойн ариутгалын байгууллага, үлдсэн 12 буюу 54.5 хувийг бусад эмнэлгийн үйлчилгээ эзэлж байна. (Хавсралт №1)

Аймгийн нутаг дэвсгэрт 2018 оны байдлаар согтууруулах ундаа худалдах зөвшөөрөлтэй 92, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 32, нийт 124 аж ахуйн нэгж, байгууллага байна. Харин тамхи худалдах тусгай зөвшөөрөлтэй 58 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Аймгийн хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмал хайх тусгай зөвшөөрөлтэй 2 аж ахуй нэгж, байгууллага *“Престиж Эксплорэйниш” ХХК*, *“Монгоулд” ХХК*, ашиглах тусгай зөвшөөрөлтэй 1 аж ахуй нэгж, байгууллага *“Мак цемент” ХХК*/ байна.

БҮЛЭГ 1. Тусгай зөвшөөрлийг хууль, журмын дагуу олгоогүйгээс орон нутгийн орлогод 15.5 сая төгрөгийн орлого дутуу төвлөрсөн байна.

1.1 Тусгай зөвшөөрөл олгоход баримтлах нормативыг тогтоосон хууль эрх зүйн орчин хангалтгүй байна.

Тусгай зөвшөөрлөөр үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн 6 төрөлд àéì аã сумын Засаг äàðга зөвшөөрөл олгож байгаа бөгөөд төрөл тус бүр дээр тогтоосон нормативыг мөрддэж, өгсөн чиглэлийг баримтлан ажиллаж байна.

ЭМЧМУАЭ, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, тамхи худалдах тусгай зөвшөөрлүүдийг олгоход мөрдөх чиглэл, норматив байршлыг хууль, журам, сайдын тушаалаар баталж, харин бусад тусгай зөвшөөрлийн хувьд тогтоосон норматив байхгүй зах зээлийн эрэлт хэрэгцээ, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтэд тулгуурлан олгож байна.

Тусгай зөвшөөрөл олгоходо баримталж байгаа чиглэл, норм, норматив, байршлын танилцуулгыг хүснэгт №1-ээр харуулав.

Хүснэгт № 1

| № | Аймгийн Засаг даргын захирамжаар зөвшөөрөл олгох аж ахуйн үйл ажиллагааны төрөл | Мөрдөж ажиллах хууль, журам | Мөрдөж ажиллах норматив |
|---|--|--|--|
| 1 | Эрүүл мэндийн байгууллага мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх | ЭМСС-ын 2015 оны 298 дугаар тушаалаар батлагдсан журам | ЭМЧМУАЭ тусгай зөвшөөрөл олгоход баримтлах чиглэлийг 2 жил тутам шинэчлэн боловсруулна |
| 2 | Боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх | Боловсролын тухай хууль | Тогтоосон норматив байхгүй суралцагчийн эрэлт хэрэгцээнд тулгуурладаг |
| 3 | Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх | Үйлдвэр худалдааны сайдын - 2005 оны 110 дугаар тушаал - 2008 оны 05 дугаар тушаал | - 1000 хүн ам тутамд 2- оос хэтрэхгүй байх - Нийслэл, аймгийн төвд 2000 хүн ам тутамд 1-ээс хэтрэхгүй, сумын төвд согтууруулах ундаа худалдаа цэг 1, согтууруулах ундаагаар үйлчлэх цэг 1 байх. |
| 4 | Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах | Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль | Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон уурхайн талбайг тусгах |
| Сумын Засаг даргын захирамжээр тусгай зөвшөөрөл олгох аж ахуйн үйл ажиллагааны төрөл | | | |
| 5 | Агаарт бохирдуулах бодис гаргадаг, физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг үйлдвэрлэл эрхлэх, суурин эх үүсвэр ашиглах | Агаарын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль | Тогтоосон норматив байхгүй агаарт бохирдуулах бодис гаргах хэмжээ, аж ахуй нэгж байгууллагын хүсэлт |
| 6 | Тамхи худалдах | Тамхины хяналтын тухай хууль | Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метрээс хол зайд орших цэгт |

Аудитаар аймаг, сумын Засаг дарга аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгоходо хууль, журамд заасан норм, норматив байршлыг мөрдөж ажилласан эсэх талаар шалгахад хэрэгжилт хангалтгүй үзүүлэлттэй байна. Үүнд:



Орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн тусгай зөвшөөрөл 6 байна

Аудитаар эрүүл мэндийн чиглэлээр шинээр тусгай зөвшөөрөл авсан байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг ЭМСС-ын 2016 оны А/258 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 2016-2017 онд баримтлах чиглэл”-тэй уялдуулан олгосон эсэхийг авч үзлээ.

Эрүүл мэндийн чиглэлээр олгосон тусгай зөвшөөрлийг тэргүүлэх чиглэл болон орон нутгийн хэрэгцээ шаардлагатай харьцуулсан судалгаа

Хүснэгт № 2

| Д/д | Шинээр тусгай зөвшөөрөл олгосон байгууллага, үйл ажиллагааны чиглэл | 2016-2017 онд баримтлах чиглэлтэй уялдсан эсэх | Орон нутгийн хэрэгцээ шаардлагатай уялдсан эсэх |
|-----|---|--|--|
| 1 | Энэрэл сувилал | T3 олгоход хязгаарлалт хийх чиглэлд орсон | Дэлгэрцогт сум болон орон нутгийн хувьд давхардалгүй, эрэлт хэрэгцээтэй. |

| | | | |
|---|---|--|---|
| 2 | “Мон хар бор” ХХК /Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний сувилал/ | T3 олгоход хязгаарлалт хийх чиглэлд орсон | Эрдэнэдалай сум болон орон нутгийн хувьд давхардалгүй, эрэлт хэрэгцээтэй. |
| 3 | “Гоогоо долгион” /Мэдрэлийн эмчийн оношлогоо,эмчилгээ/ | T3 олгоход хязгаарлалт хийх чиглэлд орсон | Аймагт мэдрэлийн хувийн эмнэлэг байхгүй. |
| 4 | “Угаал мандал мед” /Нүүр амны өвчний оношлогоо, эмчилгээ/ | T3 олгоход хязгаарлалт хийх чиглэлд орсон | Говь-Угаал суманд давхардалгүй, эрэлт хэрэгцээтэй. |
| 5 | “Хан түшиг дент шүдний эмнэлэг” /Нүүр амны өвчний оношлогоо, эмчилгээ/ | T3 олгоход хязгаарлалт хийх чиглэлд орсон | Аймгийн төвд 5 шүдний эмнэлэг байгаа. Хэрэгцээ шаардлага бага |
| 6 | “Сайн түшиг” /Ахуй шавьж, мэрэгч устгах, халдвартгүйжүүлэх үйлчилгээ/ | Тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлд орсон | Аймгийн төвд хэрэгцээ шаардлагатай. өрсөлдөөн бий болох боломжтой. |
| 7 | “СОСУ” /Ахуй шавьж,мэрэгч устгах, халдвартгүйжүүлэх үйлчилгээ/ | Тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлд орсон | Аймгийн төвд хэрэгцээ шаардлагатай. өрсөлдөөн бий болох боломжтой. |

Аймгийн ЭМЧМУАЭ тусгай зөвшөөрөл олгох комисс нь 2016-2017 онд 7 байгууллагад шинээр тусгай зөвшөөрөл олгожээ. Үүний зөвхөн 2 байгууллагын тусгай зөвшөөрөл ЭМСС-ын баталсан ЭМЧМУАЭ тусгай зөвшөөрөл олгоход баримтлах тэргүүлэх чиглэлтэй уялдсан байна. Харин 5 байгууллага буюу 71 хувь нь ЭМЧМУАЭ тусгай зөвшөөрөл олгоход хязгаарлалт хийх чиглэлд хамаарч байгаа боловч орон нутгийн хэрэгцээ шаардлагад үндэслэн олгосон байна.

ЭМЧМУАЭ тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах журмын 2.1.3¹-т заасны дагуу орон нутгийн хэмжээнд хүн амын эрүүл мэндийн бодит хэрэгцээ, шаардлагын нэгдсэн судалгаа гаргаж, саналаа дээд газартаа хүргүүлээгүй байна.

Иймд аймгийн ЭМЧМУАЭ тусгай зөвшөөрлийн комисс нь журмын дагуу ажиллаж, аймгийн хэмжээнд хүн амын эрүүл мэндийн бодит хэрэгцээ, шаардлагын нэгдсэн судалгаа гарган, журмын 1.3²-т заасны дагуу эрүүл мэндийн тусламж үйлчилгээг олон улсын стандарт, оношилгоо, эмчилгээний дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, хөдөө алслагдсан байршилд байрлан, тусламж үйлчилгээг иргэдэд ойртуулсан аж ахуйн нэгж, байгууллагад тусгай зөвшөөрлийг олгоход анхаарч ажиллах нь зүйтэй.

¹ Үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийн хэрэгцээ, шаардлагыг судалж цаашид баримтлах тэргүүлэх чиглэлийг тодорхойлон, саналаа Эрүүл мэнд, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх ажлын албандаа хүргүүлэх

² Комисс нь үйл ажиллагаандaa Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлээр тогтоосон зарчмаас гадна дор дурдсан зарчмыг баримтална. – Хүн амын эрүүл мэндийн бодит хэрэгцээ, шаардлага, эрүүл мэндийн салбарт баримталж буй тэргүүлэх чиглэлийг үндэслэх



2005 оны УХ-ын 110 дугаар тушаалыг мөрдөж байна.

Архиdan согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4³.-т заасны дагуу 2008 онд Үйлдвэр худалдааны сайдын 5 дугаар тушаалаар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоог аймгийн төвд 2000 хүн ам тутамд 1-ээс хэтрэхгүй, сумын төвд согтууруулах ундаа худалдах цэг 1, согтууруулах ундаагаар үйлчлэх цэг 1 байхаар шинэчлэн тогтоож урьд мөрдөж байсан 110 дугаар тушаалыг хүчингүй болгожээ.

Гэвч хүчингүй болсон Үйлдвэр худалдааны сайдын 2005 оны 110 дугаар тушаалаар тогтоосон нормативыг мөрдөж байна. Шалтгааныг дараах схемээр харууллаа.

Схем 1 Хууль эрх зүйн зөрчлийг харуулсан байдал



Аудитын явцад бусад аймгийн тусгай зөвшөөрөл олгох норматив мөрдөлтийг судалж үзэхэд 2008 оны Үйлдвэр худалдааны сайдын 5 дугаар тушаалыг мөрдсөн газар байхгүй, зарим аймаг 110 дугаар тушаалыг мөрдөж, ихэнх аймаг тодорхой норматив барихгүй ажиллаж байна. Иймд дээрх асуудлыг ҮАГ-аар дамжуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд уламжлуулж, шийдвэрлүүлэх шаардлагатай байна./Хавсралт №7/


Манай аймгийн хувьд 2017 оны жилийн эцсийн байдлаар нийт 46,383 хүн ам тоологдсон бөгөөд Үйлдвэр худалдааны сайдын 2005 оны 110 дугаар тушаалаар баталсан нормативаар нийт 93 цэг байхаас согтууруулах ундаа худалдах 92, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 32, нийт 124 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Норматив хангаж байгаа эсэхийг сумдаар харьцуулж үзэхэд Адаацаг, Говь-Угтаал, Дэлгэрхангай сумд заасан хэмжээнд байна. Харин 10 суманд байвал зохих хэмжээнээс 34 цэгт илүү зөвшөөрөл олгосон бөгөөд үүнээс Сайнцагаан сум

³ Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоо, төрлийн талаарх нормативыг тухайн орон нутгийн хүн амын тоо, үйлчилгээний хүрээ, эрүүл мэнд, соёлын байгууллага, оюутан, сурагчдын хичээлийн болон нийтийн байрны байршилыг харгалзан худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

дийлэнхийг буюу байвал зохих хэмжээнээс 22 цэгт илүү зөвшөөрөл олгосон байна.
/График №1 Хавсралт № 2/

График 1



Ихэнх сумдад согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоо байвал зохих хэмжээнээс илүү байгаа нь аймгийн Засаг дарга, ажил хариуцсан мэргэжилтэн ажилдаа хариуцлагагүй хандаж, мөрдөж байгаа нормативыг хэтрүүлж, хавтгайруулан олгосноос шалтгаалжээ.

Иймд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн [7.4⁴](#) дэх заалтыг хэрэгжүүлж, Үйлдвэр худалдааны сайдын 2005 оны 110 дугаар тушаалын [15](#) дэх заалтыг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Мөн 2016 онд аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам”-д өөрчлөлт оруулж тусгай зөвшөөрөл хүсэгчийн хүсэлтийг, эрх бүхий байгууллагын төлөөлөл оролцсон ажлын хэсгээр хэлэлцэж сонгон шалгаруулалтаар, тогтоосон нормативт багтаан олгох асуудлыг тусгаж өгөх шаардлагатай байна.



Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн [11.1.1⁶](#)-д заасны дагуу аймгийн ИТХ нь аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон уурхайн талбайг тусгаж өгөхөөр заасан байна.

ТТАМ-ын хайгуулын болон уурхайн талбайг тодорхойлоогүй байна.

Аудитын явцад аймгийн ЗДТГ-ын ХОХБТ-ийн хэлтсээс тодруулахад “аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлагдаагүй байгаа тул түгээмэл тархацтай ашигт малтмалын

⁴ Эрх бүхий байгууллага шаардлагатай гэж үзвэл сонгон шалгаруулалтын үндсэн дээр тусгай зөвшөөрөл олгож болно.

⁵ Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх цэгийн тоог тухайн орон нутгийн 1000 хүн ам тутамд 2-оос хэтрэхгүй байхаар тогтоосугай.

⁶ аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон уурхайн талбайг тусгах;

хайгуулын болон уурхайн талбайг тусгах ажил хийгдээгүй” гэсэн тайлбарыг ирүүлсэн бөгөөд дээрх хуулийн заалт хэрэгжээгүй байна.

Иймд аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон уурхайн талбайг тусгах талаар судалж, төлөвлөгөөнд тусгах бэлтгэл ажлыг хангах шаардлагатай байна.



Сумын Засаг дарга Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн [6.7.14⁷](#) дэх заалтыг баримтлан тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгож байгаа боловч хэмжилтийг хийж баримтжуулаагүй байна.

Энэ нь ЗГ-ын 2013 оны 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Тамхины үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих журам”-ын 5 дугаар зүйл [5.1.4⁸](#) дэх заалтыг зөрчсөн тул тусгай зөвшөөрөл олгогдсон аж ахуй нэгж, байгууллага, иргэдийн тамхины цэгүүдийн ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метрийн доторх зайлт тодорхойлсон зураглалыг нөхөн гаргаж баримтжуулан нотлох баримтыг эргэн танилцуулах талаар зөвлөмж өглөө.


1.2 Тэмдэгтийн хураамж төлөөгүй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд тусгай зөвшөөрлийг олгосон байна.

Аймаг, сумын Засаг даргаас олгох тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийн хэмжээг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар, тусгай зөвшөөрлийн хугацааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6.1-д заасны дагуу дараах эрх зүйн актуудаар тус тус тогтоосон байна.

Схем 2 Тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжтай холбоотой эрх зүйн актууд

⁷ ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метрийн дотор тамхи худалдах;

⁸ ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метрийн доторх зайлт тодорхойлсон зураглалыг сум, дүүргийн Засаг даргын Тамгиын газраар баталгаажуулсан баримт гаргуулсан байх;



Засаг даргын захирамжаар олгогдох 6 төрлийн тусгай зөвшөөрлөөс аймгийн Засаг дарга 4 төрлийн тусгай зөвшөөрлийг 2015-2017 оны хооронд 46 байгууллагад шинээр олгож, давхардсан тоогоор 223 байгууллагын хугацааг сунгасан байна. Харин сумдын Засаг даргын захирамжаар олгох 2 төрлийн тусгай зөвшөөрлөөс 2015-2017 оны хооронд зөвхөн тамхи худалдах тусгай зөвшөөрлийг давхардсан тоогоор 68 цэгт олгосон байна. /Хүснэгт №3/

Хүснэгт № 3

Тусгай зөвшөөрөл шинээр олгосон, сунгальт хийсэн байгууллагын тоо

| № | Нэр төрөл | 2015 | | 2016 | | 2017 | |
|---|-----------------------------|------|----------|------|----------|------|----------|
| | | Шинэ | Сунгальт | Шинэ | Сунгальт | Шинэ | Сунгальт |
| 1 | Архи согтууруулах ундаа | 11 | 89 | 13 | 8 | 11 | 52 |
| 2 | Эрүүл мэндийн байгууллага | | | 1 | 3 | 6 | 32 |
| 3 | Түгээмэл тархацтай АМ | 2 | | 1 | | | |
| 4 | Сургууль цэцэрлэг байгуулах | 1 | 1 | | | | 38 |

| | | | | | | | |
|----------|-----------------------------|-----------|-----------|-----------|-----------|-----------|------------|
| 5 | Тамхи худалдах /Сум/ | 15 | 0 | 32 | 0 | 17 | 4 |
| | Засаг даргын нийт | 14 | 90 | 15 | 11 | 17 | 122 |

Аудитын явцад архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамж бүрэн төвлөрсөн эсэхийг шалгахад аймаг, сумдын тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн, татварын хураагч, байцаагч нар хууль, журмаа бүрэн судлаагүйгээс тэмдэгтийн хураамжийг харилцан адилгүй ногдуулан хураасан байсан.

Иймд аймгийн ИТХ-ын 2011 оны 142 дугаар тогтоолоор тогтоосон тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээ болон улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35.3⁹ дахь заалтын дагуу тэмдэгтийн хураамжийг тооцож, төвлөрүүлэх шаардлагатай байна.

Тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг нэр төрлөөр нь задлан авч үзвэл:



71.3% | Гүйцэтгэл /Хураамж/

Архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжид 43,620.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээс 31,120.0 мянган төгрөгийг 2015-2017 онд төвлөрүүлсэн байна. Үүний 1,160.0 мянган төгрөгийг аймгийн ИТХ-ын баталсан тэмдэгтийн хураамжийн хэмжээг баримтлаагүйгээс 5 сумын 15 байгууллага илүү төвлөрүүлж, 7 сумын 41 байгууллага 13,660.0 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна. Дутуу төвлөрүүлсэн 1,000.0 мянган төгрөгийн зөрчлийг 3 сумын 3 байгууллага аудитын явцад запруулсан. Харин 5 сумын 38 байгууллагын 12,660.0 мянган төгрөгт хугацаатай төлбөрийн актыг тогтоосон. /Хавсралт №3/



97.3% | Гүйцэтгэл /Хураамж/

Тамхи худалдах тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжаас нийт 15,250.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 97.3 хувь буюу 14,850.0 мянган төгрөг орон нутгийн тэмдэгтийн хураамжийн дансанд төвлөрсөн байна. Дутуу төвлөрсөн 400.0 мянган төгрөгөөс аудитын явцад 50.0 мянган төгрөгийг орон нутгийн орлогод тушааж запруулсан бол үлдэгдэл 350.0 мянган төгрөгт хугацаатай төлбөрийн акт тогтоосон. /Хавсралт №4/



75.9% | Гүйцэтгэл /Хураамж/

ЭМЧМУАЭ тусгай зөвшөөрлөөс 2016-2017 оны хооронд 6,190.0 мянган төгрөг төвлөрөхөөс 75.9 хувь буюу 4,700.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Дутуу төвлөрүүлсэн 6 байгууллагын 1,490.0 мянган төгрөгийг барагдуулах хугацаатай төлбөрийн акт тогтоосон. Аудитын явцад төлбөрийн актын 1,070.0 мянган төгрөгийг барагдуулж, үлдэгдэл 420.0 мянган төгрөгийг 2018 оны 05 сарын 15-ны дотор барагдуулахаар болсон байна. /Хавсралт №5/

ЭМСС-ын 2015 оны А/298 дугаар тушаалаар батлагдсан “ЭМЧМУАЭ тусгай зөвшөөрлийн журам”-ын дагуу 2016 оноос тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийн орлого аймгийн Эрүүл мэндийн газрын

⁹ Энэ хуулийн 35.2.1-д заасан тэмдэгтийн хураамж төлөгчид мөн хуулийн 35.2.2 дахь заалт, энэ хуулийн 35.2.3-т заасан тэмдэгтийн хураамж төлөгчид мөн хуулийн 35.2.4 дэх заалт тус тус хамаарахгүй.

нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрч, журамд заасны дагуу зарцуулагдаж, үлдэгдэл 3,551.5 мянган төгрөгийг улсын төсвийн орлогод төвлөрүүлсэн байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 7.4.¹⁰, 7.4.4¹¹ гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймээс аймгийн Эрүүл мэндийн газарт ЭМЧҮАЭ тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийн үлдэгдэл орлогыг хуулийн дагуу аймгийн тэмдэгтийн хураамжийн дансанд төвлөрүүлж ажиллахыг зөвлөлөө.



0% | Гүйцэтгэл /Хураамж/



83.4% | Гүйцэтгэл /Хураамж/

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах тусгай зөвшөөрлөөс 2015 онд шинээр 1 сургууль, сунгалт 1 сургууль, 2017 онд 38 сургууль, цэцэрлэг сунгалтаа хийлгэж орон нутгийн төсөвт нийт 10,000.0 мянган төгрөгийн тэмдэгтийн хураамж төвлөрөх ёстой ч орлогыг төвлөрүүлээгүй байна. Энэ нь бүх сургууль, цэцэрлэгийн тухайн оны төсөвт тэмдэгтийн хураамжийн зардлыг суулгаж өгөөгүйтэй холбоотой байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг 2015 онд “Престиж Эксплорэйшин” ХХК 2 байршилд, 2017 онд “Монгоулд” ХХК 1 байршилд тус бүр 3 жилийн хугацаатай хайгуулын зөвшөөрөл авч үйлчилгээний хөлсөнд 750.0 мянган төгрөг, тусгай зөвшөөрлийн төлбөрт 242.8 мянган төгрөг төвлөрүүлэхээс 82.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт дутуу төлсөн байна.

Засаг даргын захирамжаар олгосон тусгай зөвшөөрлөөс ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах, түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрлөөс бусад 3 төрлийн тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийн орлогоос нийт 65,060.0 мянган төгрөгийн орлого төвлөрөхөөс 76.1 хувь буюу 49,510.0 мянган төгрөгийн орлого төвлөрч, 23.9 хувь буюу 15,550.0 мянган төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна. Дутуу төвлөрүүлсэн тэмдэгтийн хураамжийн 1,050.0 мянган төгрөгийн орлогыг аудитын явцад запруулж, үлдэгдэл 14,500.0 мянган төгрөгт хугацаатай төлбөрийн акт тогтоож, аудитын тайлагналын шатанд төлбөрийн актаас 11,685.0 мянган төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлээд байна. /Хавсралт №6/

Дээрх зөрчлүүд нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт 11.1.4¹², Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 43.1¹³-т заасныг хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

Иймд аймгийн Засаг дарга болон тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэнгүүдэд хуулийн дагуу баримт материалыа бүрдүүлэн, хуулийн

¹⁰ Улсын Их Хурал, Засгийн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хувь хэмжээг нь тогтоож орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, эсхүл тухайн нутаг дэвсгэрт үйлчлэх дараах татвар орон нутгийн татварт хамаарна.

¹¹ энэ хуулийн 7.3.14-т зааснаас бусад улсын тэмдэгтийн хураамж

¹² улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт,

¹³ Үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь тэмдэгтийн хураамжийн тайланг хагас, бүтэн жилээр гаргах бөгөөд хагас жилийн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 20-ны өдрийн дотор харьялах татварын албандаа гаргаж өгнө

хугацаанд тэмдэгтийн хураамжийн тайланг гарган, Татварын хэлтэст хүргүүлж, тооцоо нийлэн ажиллаж байх хугацаатай албан шаардлагыг хүргүүллээ.

Мөн Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4.3¹⁴-т заасны дагуу аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 43 тоот тогтоолоор “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам”-д хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл хүсэгчийн бүрдүүлэх баримт материалд улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримтыг нэмж оруулах нь зүйтэй байна.

БҮЛЭГ 2. Орон нутгаас олгогдсон тусгай зөвшөөрөлд тавих őйі 嘴角 хангалтгүй байна.

2.1. Архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагууд гаалийн шинжилгээний бичиггүй импортын архи худалдаж байна.

График 2

Аудитаар Хулд, Луус, Дэлгэрхангай, Дэлгэрцогт, Дэрэн, Цагаандэлгэр, Сайнцагаан сумдын архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, тамхи худалдах, ЭМЧМУАЭ болон сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийт 85 аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаатай танилцлаа. Бусад сумдын хувьд холбогдох баримт материалыг гаргуулан авч судалгааны түвшинд аудитыг гүйцэтгэсэн. Үйл ажиллагаатай танилцсан 85 аж ахуйн нэгж, байгууллагын 60 хувь буюу 51 аж ахуйн нэгж, байгууллага нь архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллага байсан.



86.3% | Импортын согтууруулах ундаа худалддаг

Архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагын 7.8 хувь нь тохирлын гэрчилгээгүй, 21.6 хувь нь галын дүгнэлтгүй, хугацаа нь дууссан, 17.6 хувь буюу 9 байгууллага кассын машин ашиглаагүй байна. Шалгалтад хамрагдсан 51 байгууллагын 86.3 хувь буюу 44 байгууллага импортын архи, согтууруулах төрлийн ундаа худалдаж, түүгээр үйлчилж байгаа боловч “Номгон рашаан” ХХК-аас бусад байгууллага гаалийн шинжилгээний бичиггүй байлаа.

Импортын архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгж, байгууллагын 97.7 хувь нь импортын архи, согтууруулах



¹⁴ Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох журмыг харьялах нутаг дэвсгэрийн иргэдийн саналыг авсны үндсэн дээр батална. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоходо аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан журмын дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсэд тухайн чөлөөт бүсийн захирагч олгоно.

ундааны гаалийн шинжилгээний бичиг байхгүй байсан нь хуурамч, эрүүл мэндийн шаардлага хангахгүй чанар муутай бүтээгдэхүүн борлуулж байх эрсдэлийг бий болгож байна.

Дээрх нөхцөл байдал үүсэхээс сэргийлэн 2004 онд аймгийн ИТХТ-ийн 101 тоот тогтоолоор “Дундговь аймагт архи, согтууруулах ундаа худалдах, хязгаарлалт”-ыг баталсан боловч тодорхой хуулийн заалтыг үндэслээгүй байна. Иймд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 43 тоот тогтоолоор баталсан “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам”-д архи, согтууруулах ундаа худалдах зарим нэг хязгаарлалт, импортын архины гаалийн шинжилгээний баримт материалыг бүрдүүлж ажиллах талаар нэмж тусгах шаардлагатай.

2009 онд аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хуралдааны шийдвэрээр аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 15 компанийд жил бүр архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг түр хугацаагаар буюу 6-7 сарын хугацаагаар олгож, тэмдэгтийн хураамжийг огт төвлөрүүлээгүй зөрчил илэрсэн.

Үндэслэл болгосон зөвлөлийн хуралдааны тэмдэглэл нь архивт хадгалагдаагүй, байхгүй учир ямар хуулийг үндэслэж олгосныг тогтоох боломжгүй байлаа.

Тус аж ахуйн нэгж, байгууллагуудын төлөөгүй тэмдэгтийн хураамжийг тооцоход 2009-2018 оны хооронд, хуулийн дагуу 5 удаа сунгалт хийгдэж, нийт 24,000.0 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн орлогод төвлөрүүлэх боломжтой байжээ.

Энэ нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль [11.1](#), [11.1.4.](#)¹⁵, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн [4.7.](#)¹⁶ дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна. Иймд уг зөрчлийг таслан зогсоож, хуулийн дагуу тусгай зөвшөөрлийг олгуулах хугацаатай албан шаардлагыг хүргүүллээ.



8 цэг
зөвшөөрөлгүй
тамхи худалдсан.

Цагаандэлгэр, Говь-Угтаал сумдад тус бүр нэг иргэн, Өндөршил суманд 6 аж ахуйн нэгж, байгууллага нийт 8 цэг тамхи худалдах зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан зөрчлийг илрүүлж, зөрчлийг арилгуулахаар албан шаардлага хүргүүлсэн. Аудитын тайлагналын шатанд Цагаандэлгэр, Говь-Угтаал сумд зөрчил гаргасан иргэдийг Зөрчлийн тухай хуулийн дагуу тус бүр 300.0 мянган төгрөгөөр тортгож, тусгай зөвшөөрлийг хуулийн дагуу олгосон байна.

Тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байгаа зөрчил илэрч байгаа нь Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байгаатай холбоотой. Иймд сумын хэсгийн мөрдөгч, цагдаа нарт Тамхины хяналтын тухай хуулийн [11.1](#)¹⁷-д заасны дагуу хяналтыг үр дүнтэй хийж, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг зөвлөлөө.

¹⁵ /улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт/

¹⁶ / согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар, согтууруулах ундаа импортлох, худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2 жилийн хугацаагаар олгож, мөн хугацаагаар тус тус сунгана./

¹⁷ Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг Засгийн газар, бүх шатны Засаг дарга, мөргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, цагдаа болон хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ.



Хайх 2, ашиглах 1
тусгай зөвшөөрөл

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах зориулалтаар “Мак цемент” ХХК –нд олгосон зөвшөөрөл 2008 онд буюу аймгийн Засаг даргад эрх шилжиж ирэхээс өмнө олгогдсон байна. Дээрх аж ахуй нэгж, байгууллагуудаас “Монгоулд” ХХК байгаль орчин хамгаалах төлөвлөгөөгөө батлуулж, “Престиж Эксплорэйнш” ХХК, “Мак цемент” ХХК – ууд төлөвлөгөөг батлуулаагүй байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх тусгай зөвшөөрөлтэй 2 аж ахуй нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг 2015, 2016 онд олгосон бөгөөд аудитын явцад тухайн аж ахуйн нэгж, байгууллагын баримт материалтай танилцах гэсэн боловч ЗДТГ-ын ХОХБТ-ийн хэлтсийн даргын 2018 оны 04 сарын 30-ны өдрийн 4/428 тоот албан бичгээр тус баримт материал байхгүй гэсэн тайлбарыг ирүүлсэн.

Харин аудитын тайлан бичигдэж дууссаны дараа тайлангийн төсөлд санал тайлбар авах үед “Урьд нь Уул уурхай асуудал хариуцаж байсан хүнтэй холбогдож баримт материалыг авлаа” гэсэн тайлбартайгаар дээрх аж ахуйн нэгж байгууллагуудын материалыг ирүүлсэн.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 21.1¹⁸ дэх заалтыг зөрчсөн тул аймгийн ЗДТГ-ын ХОХБТ-ийн хэлтсийн байгаль орчин аялал жуулчлал, ашигт малтмал, уул уурхайн бодлого хариуцсан мэргэжилтэн П.Очирбатад хариуцлага тооцох албан шаардлага хүргүүллээ.

Аймгийн татварын орлогын 2017 оны гүйцэтгэлээр 12 суманд түгээмэл тархацтай ашигт малтмалын 21,049.4 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөө батлагдаж 22,806.5 мянган төгрөгийн орлого төвлөрч, төлөвлөгөө 108.4 хувьтай биелсэн байна. Тус орлогыг төвлөрүүлэхдээ сумдын татвар, байгаль орчны улсын байцаагч нар ихэвчлэн аймгаас баталсан төлөвлөгөөг биелүүлэх зорилгоор тухайн газарт ажиллаж байгаа уул уурхайн компани, улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа барилга байгууламжийн ажлын гүйцэтгэгчээс төлбөрийг авч байна.

Харин Сайнцагаан суманд 2 иргэн сумын Засаг даргатай гэрээ байгуулан зөвшөөрөл авсан боловч гүйцэтгэлээр 26 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас 11.2 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна. Энэ нь Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1¹⁹ дэх заалтыг зөрчиж байна.

Ихэнх сумд элс хайрга ашигласны төлбөрийн хэмжээг ИТХ-ын тогтоолоор тогтоосон боловч хамааралгүй хуулийн заалтыг үндэслэл болгосон байна. Цаашид элс хайрга ашигласны төлбөрийн хэмжээг тогтоохдоо Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйл 7.4²⁰, 7.4.9²¹ дэх заалтыг үндэслэл болгох нь зүйтэй байна.

¹⁸ Төрийн аудитын байгууллага, түүний ажилтнууд бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах аливаа мэдээллийг бүрэн хэмжээгээр, чөлөөтэй, шуурхай авах эрхтэй. Энэ хуулийн 15.1-д заасан байгууллага, албан тушаалтан төрийн аудитын байгууллагаас шаардсан мэдээллийг хугацаанд нь саадгүй гаргаж өгөх үүрэгтэй

¹⁹ Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдэд олгоно.

²⁰ Улсын Их Хурал, Засгийн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хувь хэмжээг нь тогтоож орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, эсхүл тухайн нутаг дэвсгэрт үйлчлэх дараах татвар орон нутгийн татварт хамаарна:

²¹ түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр;



Аймагт хорт бодис гаргадаг 4 байгууллага байна.

Аймагт “Ган-Илч” ХХК, “Тэвшийн говь” ХХК, Дундговь-Ус ОНӨААТҮГ, Ариунболов ХХК агаарын бохирдлын суурин эх үүсвэр болон усан халаалттай зуух ашиглан дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагааг явуулж байна. Тус аж ахуйн нэгж, байгууллагуудад дээрх үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийг Эрчим хүчний тухай хуулийн 12 дугаар зүйлийн [12.4²²](#) дахь заалтын дагуу аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөл олгожээ.

Харин Аж ахуй үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн [16.3.1](#) дэх заалт нь орон нутагт хэрэгжихгүй байгаа шалтгаан нь “тус хуулийн заалтыг дагаж гарах журам, заавар гараагүй тул Эрчим хүчний тухай хуулиар зохицуулагдаж байгаа” гэсэн тайлбарыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас өгсөн.

Эрчим хүчний зохицуулах зөвлөл нь Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн [1.3.2²³](#) дахь заалтын дагуу тусгай эзэмшигч аж ахуй нэгж, байгууллагын эрчим хүчний барилга байгууламж, тоног төхөөрөмжийн угсралт аюулгүй ажиллагааны шаардлагад хяналт тавьж байна.

Аймгийн МХГ-аас 2018 онд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр дээрх аж ахуйн нэгж, байгууллагуудад хийгдсэн шалгалтаар өгсөн зөвлөмжийг орон нутагтаа хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, байгаль орчны бодлого хариуцсан харьяа агентлагаа аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлтэй ажлын уялдаа холбоотой ажиллуулахыг аймгийн ИТХ-д зөвлөж байна.

2.2. Тусгай зөвшөөрлийн хэрэгжилтэнд хяналт тавих эрх бүхий байгууллагуудын хяналт хангалтгүй байна.



ЭМЧМУАЭ комисс хяналт хийгээгүй байна.

Аймгийн ЭМЧМУАЭ тусгай зөвшөөрлийн комиссын дэргэдэх ажлын алба [/Аймгийн Эрүүл мэндийн газар/](#) нь тусгай зөвшөөрөл олгосон эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг огт хэрэгжүүлээгүй байна. Энэ нь “ЭМЧМУАЭ тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах журам”-ын 6 дугаар зүйлийн [6.2.1²⁴](#), [6.2.2²⁵](#) дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Харин Мэргэжлийн хяналтын газраас 2016, 2017 онд 35 байгууллагын үйл ажиллагааг төлөвлөгөөт хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээнд хамруулж давхардсан тоогоор 30 албан шаардлага, 17 зөвлөмж өгч зөрчил гаргасан 1 байгууллагын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох арга хэмжээ авсан байна.

²² Энэ хуулийн 12.2, 12.3-т зааснаас бусад тусгай зөвшөөрлийг аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл олгоно.

²³ Тухайн орон нутагт олгосон тусгай зөвшөөрөлийнхөө нөхцөл, шаардлагын хэрэгжилтийг хянах.

²⁴ Ажлын алба нь тусгай зөвшөөрөл олгосон эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан чиг үргийн дагуу гүйцэтгэнэ.

²⁵ Эрүүл мэндийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгосноос хойш 6 сарын дотор бүтэц үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт хийж хяналтаар илэрсэн зөрчлийг арилгуулах зөвлөмж өгнө.

Иймд ажлын алба журмын дагуу тусгай зөвшөөрөлтэй эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг гүйцэтгэж ажиллах шаардлагатай байна.



Хяналт хийгдэж байгаа ч үр дүн гарахгүй байна.
Аймгийн Засаг даргын 2016 оны А/353 тоот захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2017 оны 1 дүгээр сард согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд МХГ, Стандартчилал хэмжил зүй, Онцгой байдал, Цагдаагийн газартай хамтарсан хяналт, шалгалтыг хийсэн байна. Тус шалгалтад 53 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулж тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангаж ажиллаагүй 13 аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авсан талаар тайланд тусгасан боловч зарим аж ахуйн нэгж, байгууллагын шийдвэрийг гаргаагүй байна.

Тухайлбал: “Хос гар्यд магнаг” ХХК, “Ихэр гэр чулуут” ХХК-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох шийдвэр гаргаагүй, “Мандалговь импекс” ХХК-ны тусгай зөвшөөрлийг 2017 оны 2 дугаар сард хүчингүй болгосон боловч 2017 оны 6 сард шинээр олгосон байна.

Мөн согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хамтарсан шалгалт хийх аймгийн Засаг даргын захирамж 2017 оны 4 дүгээр сард гарсан боловч хяналт шалгалт хийгдсэн материалыг аудитын явцад ирүүлсэнгүй.

Харин аудитын тайлан бичигдэж дууссаны дараа тайлангийн төсөлд санал тайлбар авах үед “Аймгийн МХГ-аас танайд хүргүүлэх байсан байна” гэсэн тайлбартайгаар Мандалговь-Хүнс ХХК-ны үйл ажиллагаанд хийсэн шалгалтын материалыг аймгийн ЗДТГ-ын ХОХБТ-ийн хэлтэсээс ирүүлсэн.

Дундговь аймаг дахь Цагдаагийн газар, Татварын хэлтэс согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд жил бүр хяналт шалгалт хийж, зөрчил давтан гаргасан аж ахуйн нэгж, байгууллагуудын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох саналыг удаа дараа өгсөн боловч аймгийн ЗДТГ-ын ХОХБТ-ийн хэлтэсээс арга хэмжээ аваагүй зөрчил илэрлээ.

Тухайлбал: Цагдаагийн хэлтэсээс “Санаа заяа” ХХК, “Хос гар्यд магнаг” ХХК, Татварын хэлтэсээс “Галтай зээд” ХХК, “Хосгарьд магнаг” ХХК, “Тойн хайрхан” ХХК, “Ихэр гэр чулуут” ХХК, “Цант –Өлзийт” ХХК, “Сэргүүн онги” ХХК-уудын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах санал өгсөн боловч одоог хүртэл шийдвэрлээгүй үйл ажиллагаагаа явуулж байна.

Харин аймгийн МХГ-аас тусгай зөвшөөрөлтэй холбоотой гарсан зөрчил дутагдал, авах арга хэмжээний талаарх санал, зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлсэн материал байхгүй байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах үйл ажиллагаа эрхлэх, болон тамхи худалдах үйл ажиллагаанд аймаг, сумын Засаг дарга болон бусад чиглэлийн байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

2015-2017 оны хооронд орон нутгаас олгож буй тусгай зөвшөөрлийн олголтын байдалд хяналт шалгалт хийгдээгүй, тусгай зөвшөөрөл олгосон аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд нэгдсэн удирдамжаар 1 удаа хяналт, шалгалт хийгдсэн бөгөөд аудитын явцад тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх аж ахуйн үйл

ажиллагааны төрөл тус бүр дээр зөрчил, дутагдал илэрсэн нь хяналт хангалтгүй байгааг илтгэж байна.

Иймд тусгай зөвшөөрөл олгож байгаа аймаг, сумын Засаг дарга, тухайн салбарын бодлого хариуцсан хэлтэс Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн [10.1.3²⁶](#)-т заасан эрхээ хэрэгжүүлж тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаад хяналт тавих ажлыг үр дүнтэй зохион байгуулж, хяналт тавих чиг үүрэгтэй байгууллагуудаас ирүүлсэн саналыг үндэслэн холбогдох арга хэмжээг авч, үр дүн тооцож ажиллах шаардлагатай байна.

2.3. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг бүртгэж, шийдвэрлээгүй байна.

Аудитын явцад архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлын бүртгэсэн байгууллага байсангүй.

Иймээс иргэн аж ахуй нэгж, байгууллагын тусгай зөвшөөрөл авахыг хүссэн баримт материалыг 2015-2017 оны аймгийн Засаг даргын захирамжуудтай тулган шалгалаа.

Архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг шалгахад ирсэн бичгийн бүртгэл хөтлөөгүйгээс зарим албан бичиг, хүсэлтийн хариуг 1-7 сарын дараа гаргасан байна.

Тухайлбал : Сайнцагаан сумын архи, согтууруулах унаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд аудит хийх явцад “Тойн хайрхан” ХХК, “Хос гарыд магнаг” ХХК, “Ихэр гэр чулуут” ХХК-нуудын тусгай зөвшөөрлийг сунгуулах хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлээгүйгээс дээрх аж ахуйн нэгж, байгууллага тусгай зөвшөөрөлгүйгээр архи, согтууруулах ундаагаар иргэдээд үйлчилж байсан.

Мөн хугацаа дууссан болон хугацааг түдгээлзүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын судалгааг гаргаж, хянаагүйгээс Сайнцагаан сумын “Ариунболов” ХХК, “Ялгуумбилэгт” ХХК-ны супермаркетын тусгай зөвшөөрлийн хугацаа 2015 оны 11 сарын 20-нд дууссан байхад 2016 оны 8 сарын 19-нд хүчингүй болгосон байна.

Сайхан-Овоо сумын “Төгрөг баянхайрхан” ХХК, Цагаандэлгэр сумын “Хайрхан хонгор” ХХК, Дэлгэрцогт сумын “Амар баярсад дөлгөөн” ХХК-нуудын тусгай зөвшөөрлийн хугацаа 2017 оны 11 сарын 20-нд, Луус сумын “Миний найдвэр” ХХК-ны тусгай зөвшөөрлийн хугацаа 2016 оны 11 сарын 20-нд дууссан, Эрдэнэдалай сумын “ПББД” ХХК, Сайнцагаан сумын “Алтанцант” ХХК, “Говийн тэнгэр” ХХК-нуудын тусгай зөвшөөрлийн хугацааг 2015 оны 11 сарын 26-нд түдгээлзүүлсэн боловч дээрх байгууллагуудын тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлуудыг одоог хүртгэл шийдвэрлээгүй байна.

Энэ нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн [6.3²⁷](#), [12.1²⁸](#)-д, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн [6.1.²⁹](#)-д, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Согтууруулах

²⁶ тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаад хяналт тавих;

²⁷ Хэрэв хуульд өөрөөр заагаагүй, энэ хуулийн 13.1-д заасан нөхцөл байдал илрээгүй тохиолдолд зөвхөн зөвшөөрөл зээмшигчийн өргөдлийг үндэслэн 3 хоногийн дотор тусгай зөвшөөрлийн хугацааг сунгана.

²⁸ /Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, холбогдох бусад баримт бичгийг хянан үзэж, тусгай зөвшөөрөл олгох эсэх тухай асуудлыг хуульд өөрөөр заагаагүй бол өргөдөл хүлээн авснаас хойш ажлын 21 хоногийн дотор шийдвэрлэн./,

²⁹ /Аймаг, нийслэлийн Засаг даргын зөвшөөрөлгүйгээр, эсхүл зөвшөөрөлд зааснаас бусад газарт болон гар дээрээс согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно./,

ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.³⁰, 6.6³¹-д заасныг зөрчсөн тул аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн худалдаа үйлдвэрлэл үйлчилгээ, хоршооны бодлого хариуцсан мэргэжилтэн Д.Энхтуяад зөрчил арилгаж, хариуцлага тооцуулах албан шаардлагыг хүргүүлсэн.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дунд үндэслэн дараах дүгнэлт өгч байна. Үүнд:

1. Тусгай зөвшөөрөл олгоход баримтлах нормативыг тогтоосон хууль эрх зүйн орчин хангалтгүй байна.
 - ✓ ЭМЧМУАЭ тусгай зөвшөөрлийн комисс нь орон нутгийн хэрэгцээ шаардлагын нэгдсэн судалгааг гаргаж, тэргүүлэх чиглэлээ тодорхойлоогүй байна.
 - ✓ Үйлдвэр худалдааны сайдын 2005 оны 110 дугаар тушаалыг дахин мөрдсөн нь хууль эрх зүйн хувьд зөрчилтэй байна.
 - ✓ Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон уурхайн талбайг аймгийн ГЗБЕТ-нд тусгаагүй байна.
 - ✓ Тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгохдоо сургуулийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метрийн доторх зайлт тодорхойлсон зураглалыг баримтжуулахгүй байна.
2. Тэмдэгтийн хураамж төлөөгүй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд тусгай зөвшөөрлийг олгосон байна.
 - ✓ Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага тэмдэгтийн хураамжийн орлогод хяналт тавиагүй, тайланг гаргаж Татварын хэлтэстэй тооцоо нийлээгүй байна.
 - ✓ ЭМЧМУАЭ тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийн орлогын үлдэгдэл 3,551.5 мянган төгрөгийг улсын төсвийн орлогод төвлөрүүлсэн байна.
 - ✓ Сумдын тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн, татварын хураагч, байцаагч нар хууль, журмаа бүрэн судлаагүйгээс тэмдэгтийн хураамжийг харилцан адилгүй ногдуулсан байна.
3. Архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагууд гаалийн шинжилгээний бичигтүй импортын архи худалдаж байна.
 - ✓ Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудад архи, согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг хууль, журмын дагуу олгоогүй байна.

³⁰ /Хөгжлийн хэлтэс хүсэлтийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шийдвэрлэн захирамжийг 3 хоногийн дотор Мэргэжлийн хяналтын газар, Татварын хэлтэс, сумдын Засаг даргын тамгын газарт хүргүүлэх болон Вэб сайтад тавьж олон нийтэд мэдээлнэ./

³¹ /Аж ахуй нэгж иргэд нь аливаа албан тушаалтны бичиг, аман шийдвэрээр Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагаа явуулахыг хориглоно/

- ✓ Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.
 - ✓ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн **16.3.1** дэх заалт нь орон нутагт хэрэгжихгүй байна.
4. Тусгай зөвшөөрлийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий байгууллагуудын хяналт хангалтгүй байна.
- ✓ Эрүүл мэндийн газар нь тусгай зөвшөөрөлтэй эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг огт хэрэгжүүлээгүй байна.
 - ✓ Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах үйл ажиллагаа эрхлэх, болон тамхи худалдах үйл ажиллагаанд аймаг, сумын Засаг дарга болон бусад чиглэлийн байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй байна.
 - ✓ Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт хийж тодорхой арга хэмжээ авахгүй байна.
5. Тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирсэн санал, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтийг үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд:

1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар 2016 онд батлагдсан “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам”-д дараах өөрчлөлт оруулах:
 - ✓ Тусгай зөвшөөрөл хүсэлтийн хүсэлтийг эрх бүхий байгууллагын төлөөлөл оролцсон ажлын хэсгээр хэлэлцэж сонгон шалгаруулалтаар, тогтоосон нормативт багтаан олгох;
 - ✓ Архи, согтууруулах ундаа худалдах зарим нэг хязгаарлалт, импортын архины гаалийн шинжилгээний баримт материалыг бүрдүүлэх талаар нэмж тусгах;
2. Аймгийн МХГ-аас агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр өгөгдсөн зөвлөмжийг орон нутагтаа хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, байгаль орчны бодлого хариуцсан албыг аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлтэй ажлын уялдаа холбоотой ажиллуулах.

Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга болон ЭМЧМУАЭ тусгай зөвшөөрлийн комисст

1. Хүн амын эрүүл мэндийн бодит хэрэгцээ, шаардлагад үндэслэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, оношилгоо, эмчилгээний дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, хөдөө алслагдсан байршилд байрлан тусламж үйлчилгээг ойртуулсан аж ахуйн нэгж, байгууллагад тусгай зөвшөөрлийг олгоход анхаарч ажиллах;

2. Хууль, журамд заасан баримтыг дутуу бүрдүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагад тусгай зөвшөөрөл олгохгүй байх;
3. ЭМЧҮАЭ тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийн үлдэгдэл орлогыг хуулийн дагуу аймгийн тэмдэгтийн хураамжийн дансанд төвлөрүүлэх;
4. Тусгай зөвшөөрөлтэй эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг хууль, журмын дагуу хэрэгжүүлэх;
5. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирсэн тусгай зөвшөөрөлтэй холбоотой санал хүсэлтийг албан хэрэг хөтлөлтийн дагуу бүртгэж, хуулийн хугацаанд шийдвэрлэх.

Аймгийн Татварын хэлтэст:

1. Аймаг сумын засаг даргын захирамжаар олгогдож байгаа тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийн орлогын бүрдүүлэлт тавих хяналтыг сайжруулж, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжид гарсан зөрчил дутагдлын талаарх мэдээллийг аймгийн ЗДТГ-ын ХОХБТ-ийн хэлтэст мэдээлж үр дүнд хяналт тавьж ажиллах.

Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газарт:

1. Аймагт агаарын бохирдлын суурин эх үүсвэр болон усан халаалттай зуух ашиглан дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагааг явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад агаарын бохирдлыг бууруулаар асуудлаар шаардлага тавьж, аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөлтэй хамтарч ажиллах.
2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж болон сумдад ашиг олох зорилгогүйгээр ашиглаж буй элс хайрга, шавар ашиглах зэрэг үйл ажиллагаанд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, түүнтэй холбогдон гарсан журмын хүрээнд шаардлага тавьж, хэрэгжилтийг ханган ажиллах.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газарт:

1. Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй газрын үйл ажиллагаа болон орон нутагт зөвшөөрөлгүй элс хайрга ашиглаж байгаа иргэн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих.
2. Архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих /шинжилгээний бичиггүй импортын архи худалдан борлуулж байгаа эсэхэд/

Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт:

1. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон уурхайн талбайг судалж төлөвлөгөөнд тусгах бэлтгэл ажлыг хангах;
2. Аймаг сумдад ашиг олох зорилгогүйгээр ашиглаж буй элс хайрга, шавар ашиглах үйл ажиллагаанд зөвшөөрөл авах, төлөх тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоох зэрэг асуудлыг судалж, аймгийн хэмжээнд мөрдөх жишиг журмыг хуульд нийцүүлэн батлуулан хэрэгжүүлэх.
3. Аймаг сумдад тусгай зөвшөөрөлгүйгээр, ашиг олох зорилгоор элс хайрга, шавар ашиглах буй аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж хууль

журмын хүрээнд шийдвэрлэх.

4. Хууль, журамд заасан баримтыг дутуу бүрдүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагад тусгай зөвшөөрөл олгохгүй байх;
5. Архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг ногдуулахдаа улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35.3³² дахь заалтыг мөрдөх;
6. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаад хяналт тавих ажлыг үр дүнтэй зохион байгуулж, хяналт тавих чиг үүрэгтэй байгууллагуудаас ирүүлсэн саналыг үндэслэн холбогдох арга хэмжээг авч, үр дүн тооцож ажиллах;
7. Иргэд аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн тусгай зөвшөөрөлтэй холбоотой санал хүсэлтийг албан хэрэг хөтлөлтийн дагуу бүртгэж, хуулийн хугацаанд шийдвэрлэх.
8. ХОХБТ-ийн хэлтсийн дарга, худалдаа үйлдвэрлэл үйлчилгээ, хоршооны бодлого хариуцсан мэргэжилтний ажлын хариуцлага, ёс зүйг сайжруулах үүрэг даалгавар өгч, зөрчил дутагдлыг бүрэн арилгуулж, шаардлагатай гэж үзвэл эрх хэмжээнийхээ хүрээнд дахин арга хэмжээ тооцож ажиллах

Сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт:

1. Тамхины тусгай зөвшөөрөл олгогдсон иргэд, аж ахуйн нэгж, байгууллага ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метрийн доторх зайл тодорхойлсон zuраглалыг нөхөн гаргаж баримтжуулан нотлох баримтыг эргэн танилцуулах;
2. Тамхи худалдах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд Тамхины хяналтын тухай хуулийн 11.1³³ д заасны дагуу хяналтыг үр дүнтэй хийх, холбогдох арга хэмжээг авах;
3. Тусгай зөвшөөрөл олголтын тэмдэгтийн хураамжийн тайланг хуулийн дагуу хагас бүтэн жилээр гаргаж, сумын татварын улсын байцаагчтай тооцоо хийх;
4. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирсэн тусгай зөвшөөрөлтэй холбоотой санал хүсэлтийг албан хэрэг хөтлөлтийн дагуу бүртгэж, хуулийн хугацаанд шийдвэрлэх.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ

Аудитын дүн, дүгнэлтийг үндэслэн дараах саналыг хүргүүлж байна.

Үндэсний аудитын газраар дамжуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэх санал:

³² Энэ хуулийн 35.2.1-д заасан тэмдэгтийн хураамж төлөгчид мөн хуулийн 35.2.2 дахь заалт, энэ хуулийн 35.2.3-т заасан тэмдэгтийн хураамж төлөгчид мөн хуулийн 35.2.4 дэх заалт тус тус хамаарахгүй.

³³ Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг Засгийн газар, бүх шатны Засаг дарга, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, цагдаа болон хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тусын эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ.

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4/ Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоо, төрлийн талаарх нормативыг тухайн орон нутгийн хүн амын тоо, үйлчилгээний хүрээ, эрүүл мэнд, соёлын байгууллага, оюутан, сурагчдын хичээлийн болон нийтийн байрны байршлыг харгалзан худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно./ гэж заасны дагуу Үйлдвэр худалдааны сайдын 2005 болон 2008 онд тогтоосон тушаалууд эрх зүйн хувьд зөрчилтэй байна.

Гэвч 2018 оны байдлаар манай аймагт Үйлдвэр худалдааны сайдын 110 дугаар тушаалыг мөрдөж байна. Уг асуудлыг бусад аймгуудаас судалж үзэхэд 2008 оны Үйлдвэр худалдааны сайдын 5 дугаар тушаалыг мөрдсөн газар 2, 2005 оны 110 дугаар тушаалыг мөрдсөн газар 3, үлдсэн 16 аймаг буюу 76 хувь нь аль ч тушаалыг мөрдөх боломжгүй учраас тодорхой норматив бариагүй, шаардлага хангасан аж ахуй нэгж, байгууллагуудад олгодог гэсэн тайлбар өгсөн.

Засгийн газрын 2017 оны 46 дугаар тогтоолоор согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоо, төрлийн талаарх нормативыг шинэчлэн тогтоох арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад даалгасан боловч одоо болтол хэрэгжээгүй байна. /Хавсралт №7/

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

Д.ИХБАЯР

АУДИТОР

Д.ДОЛЖИНСҮРЭН

ХЯНАСАН : АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.НАРАНЦАЦРАЛ

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ ТАЙЛБАР

Төрийн Аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1-т заасны дагуу аудитын тайлангийн төслийг аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын ХОХБТ-ийн хэлтэс, Татварын хэлтэс, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Эрүүл мэндийн газар болон ажил хариуцсан холбогдох хүмүүст танилцуулж санал тайлбарыг авлаа.



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
48090 Сайнцагсан сум, Дундговь аймаг,
Улсын 7059-2494, Факс: 7059-2808,
E-mail: info@dundgov.gov.mn

2018.05.15 № 71495
танай 2018.05.11 -ны № 230 -т

Г ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

"Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн орон нутагт хамааралтай заалтын хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Цаашид Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс нь аймгийн хэмжээнд хүн амын зүүрүүл мэндийн бодит хэрэгцээ, шаардлагын нэгдсэн судалгаа гаргаж, үйлчилгээндээ олон улсын стандарт, оношлогогоо, эмчилгээний дэвшилтэг техник, технологийг нэвтрүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад тусгай зөвшөөрлийг олгоход анхаарч ажиллах болно.



0311595

D:\Аудиан бичиг\2018 ТДА5.docx



Г ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТИН ГАЗАРТ

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

48080 Сайншаган сум, Дундговь аймаг,
Утас: 7059-2404, Факс: 7059-2896,
E-mail: info@dundgovi.gov.mn

2018-05-16 № 4/515

тавшиг СДРХ № 11 -ны № 227 -тг

Г Тайлбар хургуулэх тухай

Орон нутгаас олгож байгаа тусгай зөвшөөрөл олголт болон түүнд тавих хяналт хууль журмын дагуу хийгдэж байгаа эсэхэд аудит хийж дүгнэлт гаргах, зөвлөх, танилцуулах зорилгоор хийгдсэн нийшлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж дараах тайлбарыг хургуулж байна.

1. 2017 сны 4 дүгээр сарын 24-ны өдрийн А/133 захиралж нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн дасга Л.Баяртulgын баталсан "Согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаав, тусгай зөвшөөрлийн хугацаа, нэхцэл шаардлагын хэрэгжилтэд хяналт шалтгалт хийх тухай удирдамжийг хэрэгжүүлэхээр ажлын хэсгийг баталсан. Хяналт шалгалтыг 2017 сны 5 дугаар сарын 1-5-ны өдрийн хооронд Дундговь аймат согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэгч "Мандалговь Хүнс" ХХК-ийн үйлдвэрлэглийн үйл ажиллагаанд хийж гүйцэтгэн мэдээ тайланг Налтган Мэргэжлийн хяналтын газраас хургуулсан. Аудитын шалталтын явцад холбогдох баримт бичгийг Мэргэжлийн хяналтын газраас танайд хургуулэх байсан байна.

2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл зээмшигч "Престиж Эксплорейшн" ХХК, "Монгупд" ХХК-ийн холбогдох баримт материал опциоогүй тул аудитын явцад гаргаж өнг чадаагүй болно.

Үрд нь Уул уурхайн асуудал хариуцсан мэргэжилтний ажлыг хийж байсан хүнтэй холбогдож баримт, материалуудыг нь архиваас татан авнаа.

Эндээс үзэхэд "Престиж Эксплорейшн" ХХК-ийн зүгээс түгээмэл тархацтай ашигт малтмалын 2 хайгуулын тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хусаамжид 500,000, тусгай зөвшөөрлийн талберт 72,600, гэрчилгээний үнэд 6000, "Монгупд" ХХК-ийн зүгээс 1 хайгуулын тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хусаамжид 250,000, тусгай зөвшөөрлийн талберт 10,500, гэрчилгээний үнэ болс 3000 төгрөгийг тус тус орон нутгийн төсөөт төвлөсүүлсэн байна.

Цаашид аймгийн Газар зохион байгуулалтын оронхий төвлөгөөнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг тусган ажиллах болно.

Орон нутгаас олгож буй тусгай зөвшөөрлийн олголт болсон түүнд тавих хяналт хууль журмын хэрэгжилтэд хийгдсэн нийцлийн аудитаас ирүүлсан зөвлөмжийг хэрэгжүүлж ажлын хариуцлагаа сайжруулж аянхаар тусгай зөвшөөрлийн нэхцэл шаардлагыг биелүүлж хяналт тавих ажлыг үр дүнтэй зохион байгуулж мэргэжлийн

Д. Ихбаатар

Дэшигчийн авт.

Сүүдийн талбайгийн
ашиглалт түүхийн тиймг
жилдээжийн хувь

C:\Users\Sainee\Apodata\Local\Temp\2018 ТДА4.docx

0320129

2018-5-16

байгууллагуудаас ирүүлсэн саналыг үндэслэн холбогдох арга хэмжээг тухай бүр нь
шуурхай авч холбогдох хууль, дүрэм журмын дагуу шийдвэрлүүлэн үр дүнг эргэн
мэдээлж ажиллах болно.





ДҮНДГОВЬ АЙМАГ
ТАТВАРЫН ХЭДҮЭС
46299 Монголын Сүхбаатарын
Улсын Улаанбаатар хот
Бийн албаны татуулга

2018 05 15 № 121/419
таслаа 2019 04 01 № 422 -т

г ДҮНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТИН ГАЗАРТ

Төрийн аудитын тухай хуугийн 19.3.1-т
засны дагуу тайлантгийн төсөлтэй танилцуулж
Төсөлд, хүргүүлж санал байхгүй болно.



Д.Чобаджийн
Тээвчийг чөлөөлж
жүйчилж сан бол
эзгуулж сандуур
бийрүүлж тийв.
Часахуу санхүүгийн тийв

**ДУНДГОВЬ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

48090 Сайнцагаан сум, Дундговь аймаг,

7-р баг, Залуус хороолол

Утас: 70593988, Факс: (976) 70593988

E-mail: baigali@dundgovi.gov.mn

2018.05.17 № 2/96
танай 2018. 05.11 -ны № 229 -т

Г ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ Т

Аймгийн “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн орон нутагт хамааралтай заалтын хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцав. Тайланд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой санал тайлбар байхгүйг үүгээр мэдэгдэж байна.

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Х.АНХБАЯР



D. Цэдэгжаргал
Оюунч. з
ж.ж.ж.ж.


D:\Hishgee\Toot\Alban bichig A5.doc

1200716

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТАЙЛБАР

Төрийн Аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.2-т заасны дагуу аудитын тайлангийн төсөлд дараах тайлбарыг өгч байна. Үүнд:

Дундговь аймгийн Засаг дарга, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсээс ирүүлсэн тайлбарт өгөх Аудитын газрын тайлбар

| | |
|-----------|---|
| Тайлбар 1 | <p>Тайлбарыг хүлээн авч тайлангийн Бүлэг 2.1-дэх хэсэгт “Түгээмэл мархацтай ашигт малтмал хайх тусгай зөвшөөрөлтэй 2 аж ахуй нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг 2015, 2016 онд олгосон бөгөөд аудитын явцад тухайн аж ахуйн нэгж, байгууллагын баримт материалтай танилцах гэсэн боловч ЗДТГ-ын ХОХБТ-ийн хэлтэст тус баримт материал байсангүй.” гэснийг “Түгээмэл мархацтай ашигт малтмал хайх тусгай зөвшөөрөлтэй 2 аж ахуй нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг 2015, 2016 онд олгосон бөгөөд аудитын явцад тухайн аж ахуйн нэгж, байгууллагын баримт материалтай танилцах гэсэн боловч ЗДТГ-ын ХОХБТ-ийн хэлтсийн даргын 2018 оны 04 сарын 30-ны өдрийн 4/428 тоот албан бичгээр тус баримт материал байхгүй гэсэн тайлбарыг ирүүлсэн. Харин аудитын тайлан бичигдэж дууссаны дараа тайлангийн төсөлд санал тайлбар авах үед “Урьд нь Уул уурхай асуудал хариуцаж байсан хүнтэй холбогдож баримт материалыг авлаа” гэсэн тайлбартайгаар дээрх аж ахуйн нэгж, байгууллагуудын материалыг ирүүлсэн.” гэж өөрчлөн найрууллаа. Үүнтэй холбоотойгоор аудитын явцад холбогдох материалыг олдохгүй байна гэсэн шалтгаанаар гаргаж ирүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.</p> |
| Тайлбар 2 | <p>Мөн тайлангийн Бүлэг 1.1-дэх хэсэгт “Түгээмэл мархацтай ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг 2015 онд “Престиж Эксплорэйшин” ХХК 2 байршилд, 2017 онд “Монгоулд” ХХК 1 байршилд тус бүр 3 жилийн хугацаатай хайгуулын зөвшөөрөл авч үйлчилгээний хөлсөнд 750.0 мянган төгрөг, тусгай зөвшөөрлийн төлбөрт 242.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөөт төвлөрүүлэхээс огт төлөөгүй байна.” гэснийг “Түгээмэл мархацтай ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг 2015 онд “Престиж Эксплорэйшин” ХХК 2 байршилд, 2017 онд “Монгоулд” ХХК 1 байршилд тус бүр 3 жилийн хугацаатай хайгуулын зөвшөөрөл авч үйлчилгээний хөлсөнд 750.0 мянган төгрөг, тусгай зөвшөөрлийн төлбөрт 242.8 мянган төгрөг төвлөрүүлэхээс 82.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөөт дутуу төлсөн байна.” гэж өөрчлөн найруулж бичсэн.</p> |
| Тайлбар 2 | <p>Саналыг хүлээн авч тайлангийн Бүлэг 2.1 дэх хэсэгт “Мөн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хамтарсан шалгалт хийх аймгийн Засаг даргын захирамж 2017 оны 4 дүгээр сард гарсан боловч хяналт шалгалт хийгдээгүй байна.” Гэснийг “Мөн согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хамтарсан шалгалт хийх аймгийн Засаг даргын захирамж 2017 оны 4 дүгээр сард гарсан боловч хяналт шалгалт хийгдсэн материалыг аудитын явцад ирүүлсэнгүй.</p> |
| | <p>Харин аудитын тайлан бичигдэж дууссаны дараа тайлангийн төсөлд санал тайлбар авах үед “Аймгийн МХГ-аас танайд хүргүүлэх байсан байна” гэсэн тайлбартайгаар Мандалговь-Хүнс ХХК-ны үйл ажиллагаанд хийсэн шалгалтын материалыг аймгийн ЗДТГ-ын ХОХБТ-ийн хэлтэсээс ирүүлсэн.” гэж өөрчлөн найруулж бичсэн.</p> |

ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2018 оны 05 сарын 16-өдөр

Дугаар A/8

Мандалговь

Г Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/188 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.2, 2.4, Нийцлийн аудитын түр журмын 9 дүгээр зүйлийн 9.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ Нь:

- “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн орон нутагт хамааралтай заалтын хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайлан /ДУА-2018-03-НА/-г баталсугай.
- “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн орон нутагт хамааралтай заалтын хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайланг Үндэсний аудитын газар болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /С.Сүхбаатар/, Засаг дарга /О.Бат-Эрдэнэ/ болон сумдын засаг дарга наарт тус тус хүргүүлсүгэй.
- Нийцлийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /С.Сүхбаатар/, Засаг дарга /О.Бат-Эрдэнэ/ болон сумдын засаг дарга наарт зөвлөсүгэй.
- Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2018 оны 2 дугаар улиралд гарган танилцуулахыг аудитын менежер /Х.Наранцацрай/, нийцлийн аудитын багийн ахлах аудитор /Д.Ихбаяр/ наарт үүрэг болгосугай.



Ãóí äǟ âü àéì aãdaхь Tériйn aüäèòû í ãàçðû í
тэргүүлэх àöäèòî ðû í 2018 í í û 05 äугаар ñàðû í
16 - ны өдрийн A/08 дугаар ööö àäëû í 1 äçäyûð õââñðàëò

АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Аудитын код: ДУА-2018-03-НА

Аудитын нэр : “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн орон нутагт хамааралтай заалтын хэрэгжилт”

| № | Зөрчлийн товч утга | Зөрчигдсэн хуулийн заалт | Үүнээс | | |
|---|---|---|----------------------|----------------------------|---------------|
| | | | Зөрчлийн дун сая.төг | Аудитын явцад барагдуулсан | Акт тавигдсан |
| 1 | Луус суманд зоогийн газрын үйл ажиллагаа эрхэлдэг “Буянт наран говь” ХХК – нь аймгийн Засаг даргын 2017 оны 07 сарын 18 –ны өдрийн A/253 дугаар захирамжаар архи, согтууруулах ундаагаар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн эрх авсан боловч хууль, журамд заасан баримтыг дутуу бүрдүүлж, тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг төлөөгүй. /Луус сум/ | Аж ахуйн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйл /Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг/, 11.1.4.-т /Улсын тэмдэгтийн хураамж төлсэн баримт;/, Улсын тэмдэгийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.3-т / спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход нийслэлд 600 000-1 500 000 төгрөг, аймгийн төвийн суманд 320 000-800 000 төгрөг, бусад суманд 200 000-500 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад нийслэлд 200 000-500 000 төгрөг, аймгийн төвийн суманд 160 000-400 000 төгрөг, бусад суманд 80 000-200 000 төгрөг;/, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2011 оны 142 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт-д /Улсын тэмдэгтийн хураамж тогтоох тухай/ | 0.5 | | 0.5 |

| | | | | |
|---|---|--|-----|-----|
| 2 | Хулд суманд архи согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 5 аж ахуй нэгж, байгууллага нь аймгийн Засаг даргын захирамжаар архи согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн эрх олгосон боловч хууль, журамд заасан баримтыг дутуу бүрдүүлж, тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг төлөөгүй. /Хулд/ | Аж ахуйн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйл /Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг/, 11.1.4.-т /Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;/, Улсын тэмдэгийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.3-т /спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход нийслэлд 600 000-1 500 000 төгрөг, аймгийн төвийн суманд 320 000-800 000 төгрөг, бусад суманд 200 000-500 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад нийслэлд 200 000-500 000 төгрөг, аймгийн төвийн суманд 160 000-400 000 төгрөг, бусад суманд 80 000-200 000 төгрөг;/, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 142 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт-д /Улсын тэмдэгтийн хураамж тогтоох тухай/ | 0.7 | 0.7 |
| 3 | Хулд суманд зоогийн газрын үйл ажиллагаа эрхэлдэг “Говийн тэргүүн” ХХК – нь аймгийн Засаг даргын 2017 оны 02 сарын 03 –ны өдрийн А/29 дугаар захирамжаар архи, согтууруулах ундаагаар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн эрх авсан боловч хууль, журамд заасан баримтыг дутуу бүрдүүлж, тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг төлөөгүй. /Хулд сум/ | Аж ахуйн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйл /Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг/, 11.1.4.-т /Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;/, Улсын тэмдэгийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.3-т /спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход нийслэлд 600 000-1 500 000 төгрөг, аймгийн төвийн суманд 320 000-800 000 төгрөг, бусад суманд 200 000-500 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад нийслэлд 200 000-500 000 төгрөг, аймгийн төвийн суманд 160 000-400 000 төгрөг, бусад суманд 80 000-200 000 төгрөг;/, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 142 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт-д /Улсын тэмдэгтийн хураамж тогтоох тухай/ | 0.2 | 0.2 |

| | | | | | |
|---|---|---|------|------|--|
| 4 | <p>Дэлгэрхангай суманд хүнсний жижиглэн худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг иргэн М.Норов-Эрдэнэ нь аймгийн Засаг даргын 2017 оны 07 сарын 03 –ний өдрийн А/43 дугаар захирамжаар тамхи худалдах тусгай зөвшөөрлийн эрх авсан боловч хууль, журамд заасан баримтыг дутуу бүрдүүлж, тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг дутуу төлсөн. /Дэлгэрхангай</p> | <p>Аж ахуйн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйл /Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг/, 11.1.4.-т /Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;/, Улсын тэмдэгийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.3-т /спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход нийслэлд 600 000-1 500 000 төгрөг, аймгийн төвийн суманд 320 000-800 000 төгрөг, бусад суманд 200 000-500 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад нийслэлд 200 000-500 000 төгрөг, аймгийн төвийн суманд 160 000-400 000 төгрөг, бусад суманд 80 000-200 000 төгрөг;/, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 142 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт-д /Улсын тэмдэгтийн хураамж тогтоох тухай/</p> | 0.05 | 0.05 | |
| 5 | <p>Дэлгэрцогт суманд хүнсний жижиглэн худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг “Цахир-Амардалай” ХХК нь аймгийн Засаг даргын 2017 оны 12 сарын 11 –ний өдрийн А/454 дугаар захирамжаар архи, согтууруулах худалдах тусгай зөвшөөрлийн эрх авсан боловч хууль, журамд заасан баримтыг дутуу бүрдүүлж, тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг дутуу төлсөн. /Дэлгэрцогт/</p> | <p>Аж ахуйн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйл /Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг/, 11.1.4.-т /Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;/, Улсын тэмдэгийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5.-д /тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгоход 100 000-250 000 төгрөг;/, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 142 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт-д /Улсын тэмдэгтийн хураамж тогтоох тухай/</p> | 0.2 | 0.2 | |
